## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСТИЙН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 .06.07

| № | Хуулийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ** | | | | | |
| **Зорилт 1. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг нээлттэй болгох** | | | | | |
| 1 | 8.6.19. | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүрэн хамруулах ажил зохион байгуулах | 4 дугаар сарын 25 | -Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо мэдээ, бүртгүүлээгүй хуулийн этгээдийн судалгааг 2 хэлбэрээр гаргаж, бүртгэлд бүрэн хамруулах ажлыг бүртгэлийн бүх нэгжээр дамжуулан хэрэгжүүлсэн байна. | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо мэдээ, бүртгүүлээгүй хуулийн этгээдийн судалгааг 2 хэлбэрээр гаргаж, бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийг бүртгүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллалаа.Тус аймагт бүртгэлтэй 393 хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө мэдүүлээгүй байгаа ба дээрхи хуулийн этгээдэд мэдэгдэн бүртгэлд хамруулах арга хэмжээ авч байна. |
| **II. ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ** | | | | | |
| **Зорилт 1. Хуульд заасан үндэслэлээр мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах** | | | | | |
| 17 | 6.3 | Хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлах | Байнга | Мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтласан байна. | Тайлант хугацаанд мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох үйл ажиллагаа тус хэлтэст хийгдээгүй байна. |
| 18 | 10.4 | Хүний генетик болон биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах | Байнга | Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангасан байна. | УБЕГ-аас Хүний генетик болон биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах талаар өгөгдсөн чиглэл, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллаж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19 | 10.2-10.5 | Ирц бүртгэлийн системд ажилтныг таньж, баталгаажуулах үйлдлийг биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ээс бусад биометрик мэдээллээр ашиглах ажлыг зохион байгуулах, ажилтнаас бичгээр зөвшөөрөл авах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах | 4 сарын 15 | -Ирц бүртгэлийн системд ажилтныг таньж, баталгаажуулах үйлдэлд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ээс бусад биометрик мэдээллээр ашигласан байна.<br>-Ажилтнаас бичгээр зөвшөөрөл авсан байна.<br>-Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байна. | Албан хаагчдын цагийн бүртгэлийн мэдээлэл цуглуулах ZKTeko аппликэйшн ашиглан хэлтсийн ахлан нягтлан бодогчийн суурин компьютерт суурилуулсан төхөөрөмжөөс нийт 15 албан хаагчийн гар, хурууны хээг устган албан хаагч тус бүрээс бичгээр зөвшөөрөл аван зөвхөн нүүрээр таних мэдээллийг ашиглан цагийг бүртгэж байна. Уг үйл ажиллагааг аймгийн Тагнуулын байгууллагатай хамтран зохион байгуулсан. Одоогоор хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт ороогүй. |
| **Зорилт 2: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | |
| 23 | 27 | Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор байршуулах, мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх | 5 дугаар сарын 1 | -Зөвшөөрөгдсөн байршилд байрлуулсан байна.<br>-Анхааруулгыг иргэнд саадгүй харах боломжтойгоор байршуулсан байна. | Зөвшөөрөгдсөн байршилд : Тус хэлтэс нь үйлчилгээний зааланд 1, Архивын гадна цонх хаалгыг харсан 1, сургалтын танхим, архивын дотор хаалгыг харсан 2 камерийг тус тус байрлуулсан. Уг камерууд нь бүгд дуу бичдэггүй зөвхөн дүрс бичдэг. Мөн камер ажиллаж байна гэсэн сануулгыг иргэд олон нийт хялбар харах боломжтойгоор нааж байршуулсан. |
| | | | Байнга | Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөхгүй байх. | Дүрс бичлэгийг зөвхөн хууль хяналтын байгууллагын албан тоотыг үндэслэн төлөөлөгдсөн албан хаагчидад л хуулбарлан өгдөг бөгөөд бусад тохиолдолд мэдээллийн технологийн ажилтан мэдээллийн эзнийг байлцуулан зөвхөн өөрийн мэдээлэл байгаа хэсгийг үзүүлдэг бөгөөд ингэхдээ дүрс бичлэгийг давхар бичиж авах, зураг дарахыг хатуу хориглон ажилладаг болно. Тайлант онд цагдаагийн байгууллагаас хулгайн гэмт хэргийн мөрөөр 1 удаа камер шүүж харсан. Өөр камер шүүлгэх тохиолдол гараагүй байна. |
| **IV. Сургалт, сурталчилгаа** | | | | | |
| 28 | - | Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомж, нээлттэй өгөгдлийн талаар сурталчлах, албан хаагчдын харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх | Жилдээ | -3-с доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна.<br>-Албан хаагчдын мэдлэг дээшилсэн байна.<br>-Мэдээллийн технологийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/ | УБЕГ-аас 2022 оны 04 сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан мэдээлэл технологийн ажилтны сургалтанд тус хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан хамрагдсан. Мөн сумдын улсын бүртгэгч нарт шинэ програмын онлайн сургалт 3 удаа, тоон гарын үсгийн талаарх сургалт 5 удаа, архив бичиг хэргийн талаарх сургалт 2 удаа, програм хангамж, үйлдлийн систем суулгаж ажиллуулах талаарх сургалт 1 удаа тус тус орж нийт 12 удаагийн сургалт зохион байгуулсан байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээ, сургалт зохион байгуулах | | батлан хэрэгжүүлсэн байна.<br>-Цахим хөгжлийн багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд сурталчилгааны ажлууд хийгдсэн байна. | |
| 29 | **-** | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар сурталчлах, сургалт зохион байгуулах | | | УБЕГ-аас зохион байгуулсан хувийн мэдээлэл хамгаалах тухай сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан. Мөн энэ талаар байгууллагын фэйсбүүк хаяг, цахим хаягаар дамжуулан иргэдэд тогтмол мэдээллийг хүргэн сурталчилж ажилласан |
| 30 | - | Мэдээллийн технологийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/ батлан хэрэгжүүлэх | | | УБЕГ-аас хэрэгжүүлж буй “Мэдээлэл технологийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийн дагуу хэлтсийн мэдээлэл технологийн ажилтныг тухай бүр нь хамруулан ажиллаж байна. Мөн Говь-Алтай аймаг нь “Цахим аймаг” болохоор ажиллаж байгаатай холбогдуулан аймаг орон нутгаас зохион байгуулсан мэдээлэл технологийн ажилтнуудын уулзалт ярилцлагад 2 удаа, мэдлэг олгох сургалтанд 1 удаа, Е-монголиа хөгжүүлэлтийн сургалтанд 1 удаа тус тус хамруулсан байна. |

**ХЯНАСАН:**

ХЭЛТСИЙН ДАРГА............................................... Г.ЧҮЛТЭМЖАМЦ

**БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:**

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН ..............................Э.ЦЭРЭНДУЛАМ